



ДАРХАН-УУЛ АЙМАГ
ОРХОН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 06 өдөр

Дугаар 01-А/219

Орхон сум

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалт, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.1.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.11.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Энхтал багийн Бүрэнтолгой хэсэгт үйл ажиллагаа явуулж байгаа "Дардаа нуур" ХХКомпанийн Өгөөмөр хүнсний дэлгүүрийн тамхи худалдаалах тусгай зөвшөөрлийг 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн 2028 оны 10 дугаар сарын 06-ны өдрийг хүртэлх хугацаатай олгосугай.

2.Тусгай зөвшөөрөл олгогдож байгаатай холбогдуулан тамхины худалдаа, үйлчилгээнд хяналт тавьж, холбогдох хураамжийг цаг тухайд төвлөрүүлж байхыг Татварын улсын байцаагч, Хэсгийн төлөөлөгч, Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн, багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (С.Дэлгэржаргал)-д даалгасугай.

ДАРГА



Б.ТҮМЭНЦОГТ